

Статистикийн хэлтэс


2016-11-15
Арвайхээр




ᠮᠣᠩᠭᠡᠯᠠᠯᠤᠯᠤᠰ
ᠰᠤᠲᠤᠳᠢᠰᠲᠢᠬᠢᠢᠶᠢᠨ
ᠬᠡᠯᠲᠡᠰ

ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ- ХҮН АМ

Төрсөн хүүхэд, нас барсан хүний тоо




Хүн амын ердийн цэвэр өсөлт, хүн




Аймгийн хэмжээнд 2016 оны эхний 10-р сард 2260 хүүхэд мэндэлж, 563 хүн нас барсан байна. Өмнөх оны мөн үеийнхээс төрсөн хүүхэд 33 буюу 1.4 хувиар буурч, нас барсан хүн 30 буюу 5.6 хувиар өссөн байна. Хүн амын ердийн цэвэр өсөлт өмнөх оны мөн үеийнхээс 63 хүнээр буюу 3.5 хувиар, 2014 оны мөн үеийнхээс 190 хүнээр буюу 10.0 хувиар тус тус буурчээ.

ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ- ХӨДӨЛМӨР

Шинээр бүртгүүлсэн ажилгүйчүүд
болон ажилд зуучлагдан орсон хүний
тоо

Эхний 10 сарын байдлаар ажилгүй 2016 иргэн шинээр бүртгүүлсэн байна. Шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэд өмнөх оны мөн үеийнхээс 3.6 дахин өссөн байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн
тоо


Эхний 10 сарын байдлаар хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүд 2014 байна. Энэ нь өмнөх оны мөн үеийнхээс 110 хүнээр буюу 5.1 хувиар буурч, 2014 оны мөн үеийнхээс 622 хүнээр буюу 44.6 хувиар өссөн байна.




МОНГОЛЫН СТАТИСТИКИЙН АГЫН ГЭР

ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ- ХӨДӨЛМӨР

Шинээр бий болсон ажлын байр



Шинээр бий болсон ажлын байр, салбараар, хувиар




Аймгийн хэмжээнд эхний 10 сарын байдлаар 1246 ажлын байр шинээр бий болж, өмнөх оны мөн үеийнхээс 80 буюу 6.0 хувиар буурсан байна.


Ажлын байрны 22.1 хувь нь ХАА-н салбарт, 19.2 хувь нь боловсруулах үйлдвэрт, 6.5 хувь нь барилгын салбарт, 4.3 хувь нь боловсролын салбарт, 13.2 хувь нь худалдааны салбарт, 0.4 хувь нь мэдээлэл холбооны салбарт, 34.2 хувь нь бусад салбарт бий болсон байна.

ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ- НИЙГМИЙН ДААТГАЛ , ХАЛАМЖ

Нийгмийн даатгалын сангийн орлого, сая төг



Нийгмийн даатгалын сангийн зарлага, сая төг




2016 оны эхний 10 сарын байдлаар нийгмийн даатгалын сангийн орлого 47.8 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеийнхээс 6.9 тэрбум төгрөгөөр буюу 16.8 хувиар өссөн байна.

Нийгмийн даатгалын сангийн зарлага эхний 10 сарын байдлаар 47.3 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеийнхээс 6.0 тэрбум төгрөгөөр буюу 14.5 хувиар өссөн байна.




Улсын Статистикийн Хэлтэс




ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ- НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан хүний тоо



Олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ, сая төг



Эхний 10 сарын байдлаар 33392 хүнд 7257.6 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт олгожээ. Өмнөх оны мөн үеийнхээс тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт авагчдын тоо 2217 хүнээр буюу 7.1 хувиар өсч, олгосон тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлтийн хэмжээ 373.8 сая.төг буюу 4.8 хувиар буурсан байна.



МОНГОЛЫН УЛСЫН СТАТИСТИКААГ УРГАХААНГАЙ АЙМГИЙН СТАТИСТИКААГ

ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Эрүүл мэнд

Аймгийн хэмжээнд 2016 оны эхний 10 сард 2255 эх амаржиж, 2260 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс 28 эхээр, төрсөн хүүхдийн хувьд 33 хүүхдээр буюу 1.4 хувиар буурсан байна. Нялхсын эндэгдлийн 72.7 хувь нь 1 хүртэл насандаа, 27.3 хувь нь 1-5 хүртэл насандаа эндсэн байна. Өмнөх оны мөн үеэс 1 хүртэл насандаа эндсэн хүүхэд 17 хүүхдээр, 1-5 хүртэл насандаа эндсэн хүүхэд 8 хүүхдээр тус тус өсчээ.




	2014 он	2015 он	2016 он	2016/2015 %
Амаржсан эхийн тоо	2344	2283	2255	98.7
Амьд төрсөн хүүхэд	2346	2293	2260	98.5
Эхийн эндэгдэл	-	-	2	2 дах
1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	28	31	48	154.8
1-5 хүртэл насандаа эндсэн хүүхэд	7	10	18	180.0



ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Эрүүл мэнд

Халдварт өвчний гаралт




Халдварт өвчнөөр эхний 10 сард 1992 хүн өвчилж өмнөх оны мөн үеийнхээс 1212 хүнээр буюу 2.5 дахин өссөн байна. Халдварт өвчнөөр өвчлөгсдийн 70.4 хувийг улаан бурхан, 10.8 хувийг салхинцэцэг, 6.6 хувийг тэмбүү, 2.8 хувийг сүрьеэ, 2.3 хувийг заг хүйтэн, 0.6 хувийг вирус гепатит, 1.5 хувийг трихомониаз, бусад 3.2 хувийг өвчнөөр өвчлөгсөд тус тус эзэлж байна.



Улаанбаатар

ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Гэмт хэрэг

Бүртгэгдсэн гэмт хэрэг, төрлөөр




Аймгийн хэмжээнд эхний 10 сард 424 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 20 гэмт хэргээр буюу 4.5 хувиар буурсан байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн 60.4 хувь нь сумдад, 39.6 хувь нь аймгийн төвд бүртгэгджээ.

Хулгайн гэмт хэргийн 72.4 хувийг иргэдийн орон байрны хулгай, 14.3 хувийг малын хулгай тус тус эзэлж байна. Гэмт хэрэгт холбогдсон 413 сэжигтэн яллагдагчийн 227 хүн буюу 54.9 хувь нь 18-35 хүртэлх насныхан, 137 хүн буюу 33.1 хувь нь 35-аас дээш насныхан, 49 хүн буюу 11.8 хувь нь 17 хүртэлх насныхан байна. Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчдын 13.0 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгчид, 27.8 хувь нь ажилчин, малчин, 46.4 хувь нь ажилгүй иргэд байна. Автомашин жолоодох эрхээ хасуулсан жолооч 258 болж, өмнөх оны мөн үеийнхээс 51 хүнээр буюу 16.5 хувиар буурсан байна. Гэмт хэргийн улмаас 201 хүн бэртэж, 31 хүн нас барсан байна.

ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Хөдөө аж ахуй


Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ




2016-09-30-ийн байдлаар

ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Хөдөө аж ахуй

Хураасан ургац, төмс




Хураасан ургац, хүнсний ногоо




МОНГОЛЫН СТАТИСТИКИЙН АГЫН ТӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Хөдөө аж ахуй

Бэлтгэсэн хадлан, тн-оор, сумаар



Бэлтгэсэн гар тэжээл, тн-оор, сумаар





Улсын Статистик

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

WWW.1212.mn

uvurkhangai@nso.mn

uvurkhangai.nso.mn